


**УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая. төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Тайлангийн хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
ЗОРИЛГО: БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ, АЖИЛТНУУДЫН САХИЛГА, ХАРИУЦЛАГА, БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ							
ЗОРИЛТ 1: Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх							
1.1	Цөлжилттэй тэмцэх Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенцийн талуудын XVII дугаар бага хурлын үйл ажиллагаанд сургалт зохион байгуулж, эмнэлэг дэлгэн, тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган оролцоно. /COP-17/	-	-Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо, тайлан -Эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо, хийсэн ажлын тайлан	(-)	Амилуулах суурь тусламжийн сургалтыг зохион байгуулж, шаардлагатай иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан байна.	III дугаар улиралд хийхээр төлөвлөсөн.	100%
1.2	Байгууллагын 2026-2030 онд хэрэгжүүлэн ажиллах стратеги төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллана.	-	- Батлагдсан стратеги төлөвлөгөө - Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Байгууллагын стратеги төлөвлөгөө 2025 онд дууссан	Стратеги төлөвлөгөө батлагдаж 2026 оны төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Байгууллагын 2026-2030 онд хэрэгжүүлэн ажиллах стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулахад бэлэн болсон бөгөөд ТУЗ-ийн 2026.06.25-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.	50%
ЗОРИЛТ 2: Хүний нөөцийн хөгжлийг дэмжих, бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилтнуудын сахилга хариуцлагыг сайжруулах							
2.1	Эмнэлгийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлнэ.	-	- ТУЗ-ийн шийдвэр - Шинэчилсэн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг	Эмнэлгийн дүрэм ЭМС-ын 2024 оны А/274 тоот тушаалаар, бүтэц ТУЗ-	Шинэчилсэн эмнэлгийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг ТУЗ-өөр хэлэлцүүлж ЭМЯ-нд албан бичгээр хүргүүлсэн байна.	УНТЭ-ийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн боловсруулж Захирлын зөвлөлийн 2026.03.25-ны өдрийн хоёрдугаар хурлаар	50%

			батлуулахаар ЭМС-ад хүргүүлсэн албан бичиг	ийн 2025 оны А/06 тоот тогтоолоор тус тус батлагдсан		хэлэлцүүлэн ЭМЯ болон УНТЭ-ийн ТУЗ-д хүргүүлэхээр шийдвэрлэсэн.	
2.2	Эмч, сувилагч нарын чадамжийн үнэлгээний шалгуур боловсруулж, шалгуурын дагуу шат дараалсан үнэлгээг хийнэ.	-	- Боловсруулсан чадамжийн үнэлгээний шалгуур - Үнэлгээнд хамрагдсан ажилтны тоо, тайлан	Сувилахуйн эмнэлзүйн чадамжийн үнэлгээ хийгдэж эхэлсэн	Батлагдсан шалгуурын дагуу ажилтнуудын 80 хүртэл хувийг чадамжийн үнэлгээнд хамруулсан байна	Захиргаа, хүний нөөцийн албанаас их эмчийн чадамжийн үнэлгээний шалгуур хуудсыг боловсруулан, хянуулах шатанд явж байна. Шалгуур үнэлгээний хуудас үндсэн 4 чадамжийн хэсгээс бүрдэнэ. Үүнд: 1. Суурь чадамжийн шалгуур 2. Эмнэлзүйн чадамжийн шалгуур 3. Эмнэлзүйн бус чадамжийн шалгуур 4. Их эмчийн үйл ажиллагаатай холбоотой хяналт тавих бусад нэгжийн үнэлгээний хэсгүүдээс шалгуур бүрдэнэ.	50%
2.3	Ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгох журмыг шинэчлэн батлуулж, мөрдөн ажиллана.	-	Эмнэлгийн захирлын тушаалаар батлагдсан журам	(-)	Журам батлагдаж хэрэгжсэн байна.	Захиргаа, хүний нөөцийн албанаас “Ажилтанд ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг боловсруулан эмнэлгийн захирлын 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/05 тоот тушаалаар батлуулсан. 2026 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар нийт 512 ажилтанд ур чадварын нэмэгдэл олгогдож байна.	100%

2.4	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж батлуулна.	-	Эмнэлгийн захирлын тушаалаар батлагдсан журам	2022 онд батлагдсан журмыг мөрдөн ажиллаж байна	Журам батлагдаж хэрэгжсэн байна.	Захиргаа, хүний нөөцийн албанаас архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг үндэслэн эмнэлгийн хэмжээнд мөрдөн ажилладаг “Архивын журам”-ыг шинэчлэн боловсруулж, холбогдох алба, нэгж, төв, тасгуудаас санал авч нэгтгэн удирдах албан тушаалтнуудаар хянуулж байна.	50%
2.5	Хүний нөөцийн бүртгэлийн үйл ажиллагаанд IOT технологийг нэвтрүүлж, ажлын бүтээмж тооцох системийг нэвтрүүлнэ.	-	IOT технологээр ажлын бүтээмжийг тооцсон ажилтнуудын тоо, тайлан	(-)	Хүний нөөцийн бүртгэлийн үйл ажиллагаанд IOT технологийг нэвтрүүлсэн байна.	Мэдээлэл технологийн алба, Захиргаа, хүний нөөцийн албадууд хамтран мэс заслын өрөөний ашиглалт болон эмч, эмнэлгийн ажилтны ажлын бүтээмжийг үнэлэх үйл ажиллагаанд IoT технологийг ашиглан автоматжуулж байгаа бөгөөд системийг мэс заслын өрөөнүүдээс эхлэн нэвтрүүлж байна.	50%
2.6	Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанг сурган хөгжүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Жил бүр төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилладаг	Төлөвлөсөн арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн байна.	Захиргаа, хүний нөөцийн албанаас Улсын нэгдүгээр төв эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг сурган хөгжүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%

							
2.7	Удирдах ажилтны болон эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн сонгон шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулж батлуулна.	-	Эмнэлгийн захирлын тушаалаар батлагдсан журам	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан журам	Журам батлагдаж хэрэгжсэн байна.	Батлагдсан төлөвлөгөө Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 86 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам” батлагдсантай холбоотой УНТЭ-ийн сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэн боловсруулж, төслийг эмнэлгийн захирлын 2025.08.21-ний өдрийн 1/1236 дугаартай албан бичгээр Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлсэн болно.	50%
2.8	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Жил бүр төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилладаг	Төлөвлөсөн арга бүрэн хэрэгжсэн байна.	УНТЭ-ийн 2026 оны авлига, ашиг сонирхлын эсрэг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт 12 чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулсан. <i>(Дэлгэрэнгүй тайланг хавсралтаар бэлтгэв)</i>	100%

2.9	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангана.		Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Жил бүр төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилладаг	Төлөвлөсөн арга бүрэн хэмжээнүүд хэрэгжсэн байна.	УНТЭ-ийн 2026 оны авлига, ашиг сонирхлын эсрэг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт 12 чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулсан. (Дэлгэрэнгүй тайланг хавсралтаар бэлтгэв)	100%
ЗОРИЛТ 3: Байгууллагын соёл, үйлчилгээг сайжруулах, эерэг хандлага, манлайллыг хөгжүүлэх							
3.1	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны дарга, гишүүдийн нээлттэй сонгон шалгаруулж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сайжруулах сургалт, арга хэмжээг тасралтгүй зохион байгуулна.	-	- ЭМЯ-ны дэргэдэх Ёс зүйн хорооны тогтоол - Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2025 онд салбар хорооны бүрэн эрхийн хугацаа дууссан	Тогтоолоор хорооны бүрэлдэхүүн шинэчлэгдэн батлагдаж, төлөвлөсөн арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн байна.	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дэргэдэх "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо"-ны дарга, орлогч дарга, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулан тус Хорооны гишүүний нээлттэй сонгон шалгаруулалтыг Захиргаа, хүний нөөцийн албанаас 2026.03.03-2026.04.17-ны өдрийг дуустал зохион байгуулсан. Эмнэлгийн ерөнхий захирлын 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/138 тушаалаар Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны гишүүдийг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үүрэг чиглэл бүхий "Ажлын хэсэг" томилогдон ажиллаж байна.	70%

3.2	Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад сургалтад хамрагдсан эмч мэргэжилтнүүдийн дунд “KNOWLEDGE SHARING” буюу олж авсан мэдлэг мэдээллээ хуваалцах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, тайлан	(-)	Арга хэмжээг амжилттай зохион байгуулсан байна.	“Knowledge sharing” буюу гадаад сургалтаас олж авсан мэдлэг мэдээллээ хуваалцах чиглэлээр 5 удаагийн мэдээлэл хийгдсэн. 1. 2026 оны 02 сарын 24-нд УХСТ-ийн ахлах сувилагч Ө.Сосорбурам Япон улсад 2. 2026 оны 05 сарын 05-нд БТ-ийн ахлах сувилагч Э.Ганболор, ДШСДТ-ийн зохицуулах сувилагч М.Бямбаа, ХҮСҮТ-ийн ахлах сувилагч Д.Жимсээ, ЕМЗТ-ийн зохицуулах сувилагч Л.Цацалмаа нар БНХАУ-ын ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн нэгдсэн эмнэлэгт 3. 2026 оны 06 сарын 09 Сувилахуйн албаны арга зүйч Ц.Амаржаргал, ДШСДТ-ийн ахлах сувилагч Б.Отгонбаяр, БШГМЗТ-ийн ахлах сувилагч М.Дуламсүрэн, ЯТТ-ийн ахлах сувилагч Т.Баянсүрэн нар Хөх хотын Монгол эмнэлэгт ажлын байрны 5 хоногийн ажлын байрны сургалтад хамрагдсан тухай мэдээллийг тус тус танилцуулсан.	100%
3.3	Байгууллагын соёлыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	2013 онд тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан	Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.	2026 оны III, IV дүгээр улиралд хийхээр төлөвлөж байна.	

ЗОРИЛТ 4: Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах, эрсдэлийн менежментийг бэхжүүлэх

4.1	Эмнэлзүйн төв тасгуудын нийтлэг, өвөрмөц, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг баталж, удирдлагын дүн шинжилгээ хийж хэвшүүлнэ.	-	- Батлагдсан шалгуур үзүүлэлтүүд - Удирдлагын дүн шинжилгээний тайлан	ЭМС-ын 2022 оны А/346 тоот тушаал	Шалгуур үзүүлэлтийн үр дүнг хэлэлцсэн удирдлагын дүн шинжилгээний тайлан гарсан байна	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын алба нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагыг боловсронгуй болгох, чанарын үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг үнэлэх, мэдээлэх, дүн шинжилгээ хийх тогтолцоог сайжруулах зорилгоор “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын үндсэн болон өвөрмөц шалгуур үзүүлэлтийг батлах журам”-ын төслийг боловсруулсан. Уг журам нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын үндсэн болон өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, тогтмол мэдээлэх, дүн шинжилгээ хийх, улсын дундаж болон байгууллагын зорилтот түвшинтэй харьцуулан үнэлгээ, дүгнэлт өгөх, чанарын үзүүлэлтийн хэрэгжилтийг ханган ажиллахад чиглэгдсэн. 2026 оны эхний улиралд эмнэлэгт бүртгэгдсэн нас баралтын тохиолдлуудад чанарын дүн шинжилгээ хийж, эмч нарын яриан дээр мэдээлэл хийсэн. Мөн ЭМС-ын 2022 оны А/346 тоот тушаалын 3-р хавсралтын дагуу I дүгээр	50%
-----	--	---	--	-----------------------------------	---	---	-----

						улирлын Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын нийтлэг болон өвөрмөц шалгуур үзүүлэлтийг гаргаж дүн шинжилгээ хийсэн.	
4.2	Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын журмыг шинэчлэн, батлуулж хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Эмнэлгийн захирлын тушаалаар батлагдсан журам	(-)	Журам батлагдаж хэрэгжсэн байна.	Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд байгууллагын “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын журам”-ыг шинээр боловсруулах ажлыг эхлүүлсэн. Эхний хагас жилийн байдлаар үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилтоос “Зөв танин тодруулах журам, “Үйлчлүүлэгчийг унах эрсдэлээс сэргийлэх журам”, Мэс заслын аюулгүй байдлын журам” журмууд хэрэгжиж байгаа бөгөөд шинэчлэх төслийг боловсруулан эмнэлзүйн төв, тасгуудаас санал авч нэгтгэх ажил хийгдэж байна. Саналуудыг тусган сайжруулсны дараа байгууллагын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулахаар төлөвлөсөн.	50%
4.3	Эмнэлгийн хэмжээнд тохиолдолд суурилсан хариу арга хэмжээг сайжруулан ажиллана.	-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	85 тохиолдлыг бүртгэж, хариу арга хэмжээ авч ажилласан.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	ЭМС-ын 2022 оны А/112 тушаал болон УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2023 оны А/112 тоот журмын дагуу тохиолдлыг тасаг, төв алба бүрд бүртгэх мэдээлэх үйл ажиллагааг идэвхижүүлж 2026 оны эхний хагас жилийн	100%

						байдлаар эмнэлгийн хэмжээнд нийт 63 тохиолдол бүртгэгдэн мэдээлэгдсэн байна. Бүртгэгдсэн тохиолдлуудад дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тодорхойлон, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх болон эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээ авах зөвлөмжийг ЭМТҮЧАБА-наас хүргүүлсэн. 2026 оны эхний хагас жилд бүртгэгдсэн тохиолдлын 54 (79.4%)-д тасаг, алба, төв дотооддоо хариу арга хэмжээ авч шийдвэрлэсэн бол үлдсэн 9(20.6%) тохиолдолд нь ЭМТҮЧАБА-наас хариу арга хэмжээ авч шийдвэрлэсэн.	
4.4	Эмнэлгийн хэмжээнд эрсдлээс сэргийлэх, эрсдэл бууруулах үйл ажиллагааг сайжруулна.	-	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	48 арга хэмжээ бүхий эрсдэлийн төлөвлөгөө боловсруулж ажилласан	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний эрсдэлийг эрт илрүүлж, эрсдэлээс сэргийлэх, бууруулах зорилгоор Ерөнхий захирлын 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “УНТЭ-ийн тасаг, төв, албадын тусламж үйлчилгээний чанар болон эрсдэл хариуцсан ажилтны жагсаалт батлах тухай” А/375 тоот тушаалаар нийт 41 ажилтныг төв, тасаг, албадын эрсдэл хариуцсан ажилтнаар томилон ажиллуулж байна. Эхний хагас жилийн байдлаар ГЭТ, Угаалгын нэгдсэн тасаг, Амбулатори, Зүрхний төв, Мэдрэлийн	100%

						эмнэлзүйн төв, Техникийн алба, Инженер байгууламжийн алба, Дүрслэл оношлогооны төв, Хоол үйлвэрлэлийн нэгдсэн тасгуудад эрсдэлийн үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.	
4.5	Хавдрын хими эмчилгээний нэгдсэн нэгжийг байгуулах бэлтгэл ажлыг хангана.	(улсын төсөв)	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Хавдрын 2 эмч бэлтгэгдсэн, ЦЭСЧШСТ, БШГМЗТ-т хими эмчилгээ тогтмол хийгдэж байна.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	2026 оны III, IV дүгээр улиралд хийхээр төлөвлөж байна.	
4.6	Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх ISBAR зөвлөмжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана.	-	Зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын тайлан	Эмч дуудах бүртгэл үүсгэж ажилласан.	Арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна	2026 оны III, IV дүгээр улиралд хийхээр төлөвлөж байна.	
4.7	Цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод хяналтын хуудсыг төвийн тусламж үйлчилгээний онцлогийг тусган боловсруулж ЦААХА-аар батлуулан, дотоод хяналтын үйл ажиллагаанд ашиглана.	-	Батлагдсан хяналтын хуудсаар хийгдсэн дотоод хяналтын тайлан	(-)	Тусламж үйлчилгээний 75 хүртэл хувийг хяналтын хуудсаар үнэлсэн байна.	Эмнэлгийн захирлын тушаалаар батлагдсан хяналтын хуудсаар ДОТ болон Цөмийн онош зүйн тасагт 1-р улиралд 1 удаа дотоод хяналт хийсэн. Хяналтын үеэр рентген аппаратны өрөөнүүдийн ажиллагаагүй байсан гэрлүүдийг сольж, цацрагийн тэмдэг тэмдэглэлээ болон тусгаарлах бүсийг шинэчилсэн. Мөн 12 рентген туяа бүхий өрөөнд цацрагийн хэмжилтийг “ХАБУЛ” мэргэжлийн лабораториар	100%

						хийлгэсэн. Ажлаас урт хугацааны чөлөө авсан болон ажилаас чөлөөлөгдсөн 4 ажилтны дозиметрийг шилжүүлж, шинээр 5 ажилтанд дозиметр худалдан авч хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан.	
4.8	Сувилахуйн тусламж үйлчилгээний үнэлгээнд чанарын шалгуур үзүүлэлтийг боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Боловсруулж батлуулсан чанарын шалгуур үзүүлэлтүүд	(-)	Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 90-ээс дээш хувьтай байна	Сувилахуйн албанаас сувилахуйн тусламж үйлчилгээний аюулгүй байдлыг 1. Эмнэлэгт тохиолдсон холголт цооролтын хувь 2. Үйлчлүүлэгч танин тодруулахтай холбоотой гарсан алдаа, зөрчлийн хувь гэсэн шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд 2026 оны эхний хагас жилд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг зөрчсөн алдаа тохиолдол гараагүй байна. Тусламж, үйлчилгээний тоо хэмжээний нийтлэг шалгуур үзүүлэлтийг 3. Сувилахуйн анхан шатны бичиг, баримт хөтлөлтийн хувь 4. Эмчилгээ, сувилгааны стандарт, заавар мөрдөлтийн хувь гэсэн үзүүлэлтээр дүгнэдэг бөгөөд баримт хөтлөлтийн хувь өмнөх оныхоос 1%-иар дээшилсэн, стандарт заавар хөтлөлтийн хувь	100%

						өмнөх оны мөн үеийнхтэй адил байна.	
ЗОРИЛТ 5: Санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, эм болон бараа материалын нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх							
5.1	Агуулахын нэгдсэн системийн хэрэгжилтийг сайжруулах, онош, оношийн хамааралтай бүлгээр өртөг тооцох боломжийг бүрдүүлнэ.	-	- Системийг хөгжүүлсэн модулийн тоо - Ажил хүлээлцсэн акт	Эмнэлзүйн системээс өгөгдлөө шүүж гараар тайлан бэлддэг.	Агуулахын нэгдсэн систем үйл ажиллагаанд бүрэн нэвтэрсэн байна.	Агуулахын удирдлагын системийг ЭМЯ-ны хөрөнгө оруулалттайгаар эмнэлэгт нэвтрүүлж, ашиглалтын түвшинд бүрэн шилжүүлж зарим шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг хийж байна. Тус системийг нэвтрүүлснээр эмийн мастер дата үүсч санхүү болон эмнэлгийн eHealth систем хоорондоо интеграци хийж эмийн мэдээлэл бүрэн солилцох боломжтой болсон. Мөн эмийн захиалга нь зарлага болон хөрвөж санхүүгийн системд автомат бичилт хийгдэж оношийн хамааралтай бүлгээр өртөг тооцох боломжийг бүрдүүлсэн.	100%
5.2	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд иж бүрэн дүн шинжилгээ хийж, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулна.	-	Дүн шинжилгээний тайлан	(-)	Дүн шинжилгээний тайлан гарч удирдлагын түвшинд танилцуулагдсан байна.	Эдийн засаг, маркетингийн алба нь байгууллагын санхүүгийн иж бүрэн шинжилгээг сүүлийн 10 жилээр буюу 2016-2025 оны санхүүгийн аудитлагдсан тайланг хамруулан хийсэн. 2025 оны санхүүгийн тайланд үндэслэн байгууллагын өртгийн тооцооллыг дээрээс доош өртөг тооцох аргачлалын дагуу хийсэн. Санхүүгийн шинжилгээг 2026 оны 06 дугаар сарын 22-ны	100%

						өдөр Эрүүл мэндийн сайдад танилцуулсан.	
5.3	Байгууллагын худалдан авах ажиллагааны журмыг шинэчлэн батлуулна.	-	Эмнэлгийн захирлын тушаалаар батлагдсан журам	2020 онд батлагдсан журамтай	Журам батлагдаж хэрэгжсэн байна.	2026 оны III, IV дүгээр улиралд хийхээр төлөвлөж байна.	
5.4	Эмнэлгийн хэмжээнд хэрэглэгдэж буй бичил биетний эсрэг эмийн хэрэглээ, үр нөлөөнд судалгаа хийж судалгааны үр дүнд суурилан хангалт нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллана.	-	- Хийгдсэн судалгааны үр дүн - Эмийн хэрэглээ зардлыг бууруулсан мөнгөн дүн	Жил бүр судалгааг гарган ажилладаг.	Бичил биетний эсрэг эмийн хэрэглээ, зардлыг 5-10 хувиар бууруулсан байна.	2026 оны эхний хагас жилийн байдлаар бичил биетний эсрэг эмийн хэрэглээнд судалгаа хийж дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд: 1. 2026 оны 1-5 сард эмч нарын өвчний түүхэнд хяналт хийж антибиотик хэрэглээний үндэслэл бичилтийг сайжруулсан. 2. Таамаг эмчилгээ эхлүүлсэн антибиотик нь нян судлалын шинжилгээний хариутай таарч байгаа хувь нэмэгдсэн байгааг баталсан. 3. Эмчилгээний удирдамжийн дагуу антибиотик эмчилгээ хийх тохиолдлын хувь нэмэгдсэн. 4. Суралцагч эмч нарт антибиотек эмчилгээний талаарх онолын мэдлэг олгосон. 5. Бусад эмнэлгээс шилжин ирж байгаа эмчлүүлэгч нар хязгаарлалттай хэрэглэх антибиотик эмчилгээг эхлүүлээд	100%

						шилжин ирж байгаа тохиолдол ихэссэн бөгөөд тавих хяналтыг сайжруулсан. 6. 2026 оны 2 дугаар сараас эхлэн клиник эм судлаач антибиотик эмчилгээг хязгаарлалтын хуудасны дагуу хяналт тавьж цохож эхэлсэн. Ингэснээр эмнэлгийн нөөц антибиотикийн хэрэглээ 8,1 хувиар буурсан, 2025 оны 1-5 сарын нийт антибиотик эмийн зарцуулсан төсөв 490,8 сая төгрөг, 2026 онд 436,6 сая төгрөг болж буурсан байна.	
5.5	Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад суралцагчдын ирцийг ERP системээр 100% бүртгэдэг болох, ERP системийн бүртгэлийг үндэслэн цалинг олгох хяналтыг сайжруулна.	-	Ирцийн бүртгэлийн тайлан, түүнийг үндэслэн олгосон цалингийн тооцоо	ERP системээр бүртгэх үйл ажиллагааны хэрэгжилт 50%	Суралцагчдын ирцийг ERP системээр 100% бүртгэдэг болж бүртгэлийг үндэслэн цалинг олгож хэвшсэн байна.	Сургалт эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны албанаас суралцагч эмч нарын ажлын цагийг ERP.E-MONGOLIA.MN цахим системээр 100% бүртгэж хэвшээд байна. Үндсэн мэргэшлийн сургалтад суралцагчдын цалингийн санхүүжилтийг erp.emongolia.mn-р бүртгүүлсэн ажлын цагийн ирцэд үндэслэн багшийн журнал, суралцагчийн үнэлгээ, үзүүлсэн тусламж үйлчилгээтэй уялдуулан хянаж, нийт ажилласан цагийн тооцоог гарган ЭМХТ-ийн үндсэн мэргэшлийн сургалт хариуцсан мэргэжилтэнд хянуулан ажиллаж байна.	100%

ЗОРИЛТ 6: Эмнэлгийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэн нутагшуулах							
6.1	Дурангаар донорын элэг тайрах мэс заслын эмчилгээг нутагшуулна.	-	Амжилттай хийсэн тохиолдлын тоо	1 тохиолдол	5-6	Эхний хагас жилийн байдлаар 3 тохиолдолд бие даан амжилттай хийсэн.	100%
6.2	Хоол боловсруулах замын цэс соронзон /магнетик/ мэс заслын технологийг нэвтрүүлнэ.	-	Амжилттай хийсэн тохиолдлын тоо	1 тохиолдол	1-2	Эхний хагас жилийн байдлаар 2 тохиолдолд хийсэн.	100%
6.3	Элэг шилжүүлэн суулгах реципиентийн тархины хаванг илрүүлэх зорилгоор харааны мэдрэлийн диаметрийг хэмжих технологийг нэвтрүүлнэ.	-	Тохиолдлын тоо	Суурь бэлтгэл 2024 онд эхэлсэн	3-4	Эхний хагас жилийн байдлаар элэг шилжүүлэн суулгах реципиентийн тархины хаванг илрүүлэх зорилгоор харааны мэдрэлийн диаметрийг хэмжих технологийн тохиолдол хийгдээгүй байна. Тохиолдол гарсан үед эмч мэргэжилтэн, тоног төхөөрөмж бүрэн бэлтгэгдсэн.	100%
6.4	ICG-тэй хавдрын тунгалгийн булчирхайг бүрэн түүх технологийг нэвтрүүлнэ.	-	Амжилттай хийгдсэн эмчилгээний тоо	Эмчийн баг бэлтгэгдсэн	15-20	2026 оны III, IV дүгээр улиралд хийхээр төлөвлөж байна.	
6.5	Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын үеийн дархлал эмчилгээг эхлүүлнэ.	-	Хийгдсэн эмчилгээний тоо	Эмчилгээний эмч, сувилагч бэлтгэгдсэн	5-10	Эхний хагас жилийн байдлаар тохиолдол хийгдээгүй байна.	
6.6	Хавдартай түрүү булчирхайг хэвлийн дурангаар авах мэс заслыг нэвтрүүлнэ.	-	Хийгдсэн мэс заслын тоо	Эмчийн баг, тоног төхөөрөмж бэлтгэгдсэн	8-10	2026 оны III, IV дүгээр улиралд хийхээр төлөвлөж байна.	
6.7	Тархины деменци (зөнөгрөл), паркинсон, эпилепсийн голомт тодорхойлох шинэ аргачлалыг нэвтрүүлнэ.	-	Шинэ аргачлалаар оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	Эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн	5-8	2026 оны IV дүгээр улиралд хийхээр төлөвлөж байна.	

6.8	Элэг цөсний замын саатлын SPECT/CT оношилгоог нэвтрүүлнэ.	-	Оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	Эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн	5-6	Эхний хагас жилийн байдлаар 1 тохиолдолд хийсэн.	100%
6.9	Зүрхний дутагдлын үед ховдлын агших чадварыг сайжруулах пейсмакэр эмчилгээг нэвтрүүлнэ. (CRT)	-	Эмчилгээ хийгдсэн үйлчлүүлэгчийн тоо	Эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн	2-5	Эхний хагас жилийн байдлаар 5 тохиолдолд хийсэн.	100%
6.10	Зүрхний СПЕКТ/СТ шинжилгээг нэвтрүүлж, титэм судасны эмгэгүүдийн оношилгоог сайжруулна.	-	Хийгдсэн шинжилгээний тоо	Эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн	30-40	Эхний хагас жилийн байдлаар 10 тохиолдолд хийсэн.	100%
6.11	Ясны хэмийн эдийн шинжилгээнд дархан гистохими CD34, p53, CD117 биомаркер илрүүлэх аргыг нэвтрүүлнэ	-	Хийсэн шинжилгээний тоо	Хүний нөөц бэлтгэгдсэн	25-30	Эхний хагас жилийн байдлаар 10 тохиолдолд хийсэн.	100%
6.12	Суулгац эрхтний (элэг, бөөр, бусад) үйл ажиллагааны алдагдлыг оношлох зорилгоор хийгдэх биопсийн шинжилгээнд дархан гистохимийн шинжилгээний аргаар C4d, CMV, BK virus зэрэг эсрэг биетүүдийг илрүүлэх оношилгоог нэвтрүүлнэ.	-	Оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	Хүний нөөц бэлтгэгдсэн	4-5	Эмнэлзүй эмгэг судлалын лаборатори нь эхний хагас жилийн байдлаар CMV эрхтэн шилжүүлэн суулгасан үйлчлүүлэгч бүрт, C3, C1 эсрэг биетийг шаардлагатай үйлчлүүлэгч бүрт үзэж байна. C4d болон BK virus илрүүлэх тохиолдол хийгдээгүй байна.	50%
6.13	Дурангийн оношилгоонд AI технологийг нэвтрүүлнэ.	-	Хийсэн ажлын тайлан	Эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн	10	Дурангийн оношилгооны аппарат суурилагдсан. Тагнуулын ерөнхий газарт ажиллуулах зөвшөөрөл хүсэлт илгээсэн хариу хүлээж байна.	50%

6.14	Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтад орсон меньерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн мэс заслыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллана.	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2025 онд 2 эмч Малайз Улсын Малай их сургуулийн эмнэлэгт бэлтгэгдсэн	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна	2026 оны III, IV дүгээр улиралд хийхээр төлөвлөж байна.	
6.15	Үений эмгэгүүд, шөрмөс, мөгөөрсний гэмтлийн үеийн PRP, PRF, Stemcell эмчилгээг тогтмол хийж нутагшуулна	-	Эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	2 тохиолдол	Тус бүр 10-аас дээш тохиолдолд	Эхний хагас жилийн байдлаар 3 тохиолдолд хийсэн.	100%
6.16	МУХЖТ 2.1.4.1 Урологийн салбарт робот мэс заслыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлнэ.	(Хөрөнгө оруулалт)	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	(-)	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Урологи-андрологийн төвд 7 сард робот мэс заслын аппарат суурилагдахаар төлөвлөгдөж байгаа бөгөөд сургалтын үйл ажиллагаа 11 сард дуусаж 12 сард бүрэн ашиглалтад орно.	50%
6.17	Бөөр шээсний замд хийх мэс засалд хэвлийн дурангаар хийгдэх мэс заслын тоог нэмэгдүүлнэ.	-	Хийгдсэн мэс заслын тоо	Нийт мэс заслын 15 хувийг эзэлж байна	Дурангийн мэс заслыг 20% хүртэл нэмэгдүүлнэ.	Бөөр шээсний замд хийх мэс засалд хэвлийн дурангаар хийгдэх мэс заслын тоо өмнөх оны мөн үеийнхтэй адил 10 гаруй хувьтай байгаа бөгөөд 2026 оны жилийн эцэст 20 хувьд хүргэнэ.	50%
6.18	Түрүү булчирхайн хорт хавдрын Lu-177 PSMA I and T эмчилгээг Монгол улсад нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлнэ.	20.0 сая (үйл ажиллагааны орлого)	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	2024 оноос эхэлсэн төсөл олон улсын санхүүжилт байхгүйтэй холбоотой түр зогссон байна.	50%
ЗОРИЛТ 7: Нэгдсэн менежментийн тогтолцооны гүйцэтгэлийг нэмэгдүүлэх, дотоодын болон хөндлөнгийг аудитад хамрагдах							
7.1	Мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC27001:2022 стандартын баталгаажилт хийлгэнэ.	15.0 (үйл ажилла	Баталгаажилтын гэрчилгээ	(-)	Баталгаажилт хийгдсэн байна.	УНТЭ-ийн Мэдээлэл, технологийн алба нь “Мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC27001:2022”	

		гааны орлого)				стандартыг нэвтрүүлэхээр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж, стандартын зохих шаардлагыг хангаснаар 2026 оны 3 дугаар сарын 09-ний өдрөөс 3 дугаар сарын 13-ний өдрүүдэд Мон Майнинг Сертификейшн ХХК-аар баталгаажилтын аудит хийлгэж баталгаажуулалтын гэрчилгээг авсан.  <i>Баталгаажилтын гэрчилгээ</i>	100%
7.2	Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага MNS ISO 9001:2016 стандартын баталгаажилтад хамрагдаж гэрчилгээ сунгуулна.	15.0 (үйл ажилла гааны орлого)	Баталгаажилтын гэрчилгээ	2023 онд стандартыг нэвтрүүлж баталгаажилтын гэрчилгээ авсан	Баталгаажилт хийгдсэн байна.	2026 оны IV дүгээр улиралд баталгаажилтад хамрагдана.	
7.3	Эмнэлзүй эмгэг судлалын нэгдсэн лаборатори “Эрүүл мэндийн лаборатори Чанар ба чадавхад тавих шаардлага MNS ISO 15189:2024” стандартаар итгэмжлүүлнэ	10.0 (үйл ажилла гааны орлого)	Итгэмжлэгдсэн гэрчилгээ	Итгэмж лэлийн хугацаа дууссан	Итгэмжлэгдсэн байна.	Эмнэлзүй эмгэг судлалын нэгдсэн лаборатори нь 2026 оны 5 дугаар сарын 26,27,28-ны өдрүүдэд “Эрүүл мэндийн лаборатори Чанар ба чадавхад тавих шаардлага MNS ISO 15189:2024” стандартаар Үндэсний	50%

						итгэмжлэлийн төвийн баталгаажилтад хамрагдсан бөгөөд сайжруулалтын зөвлөмжийг хүлээн авсан.	
ЗОРИЛТ 8: Сургалт эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх							
8.1	“Эрдмийн чуулган-47” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.	10.0 (үйл ажиллаг ааны орлого)	Хэвлэгдсэн товхимол	46 удаа зохион байгуулагд сан	Хурлын товхимол хэвлэгдсэн байна.	2026 оны IV дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн	
8.2	“Эмнэлзүйн ховор тохиолдлын үндэсний чуулган-6” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.	10.0 (үйл ажиллаг ааны орлого)	Хэвлэгдсэн товхимол	5 удаа зохион байгуулагд сан	Хурлын товхимол хэвлэгдсэн байна.	“Эмнэлзүйн ховор тохиолдлын үндэсний чуулган–VI” 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Чуулганд 21 аймаг, 9 дүүргийн төр болон хувийн хэвшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс нийт 110 тохиолдол ирүүлсэн бөгөөд 20 илтгэлийг аман болон ханын илтгэлийн хэлбэрээр хэлэлцүүлж шилдэг илтгэл, илтгэгч нараа шалгаруулсан. Мөн хурлыг товхимолыг хэвлэж эмнэлгийн номын санд байршуулсан бөгөөд цахимаар гадаад цахим хуудсанд байршуулсан.	100%

						 Хэвлэгдсэн товхимол	
8.3	Эмнэлзүйн сургагч багш нарыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулна.	1.0 (үйл ажиллаг ааны орлого)	Сургалтын тайлан	Нийт 89 эмнэлзүйн сургагч багштай.	Нийт багш нарын дунд 1-2 удаа сургалт зохион байгуулсан байна.	Сургалтыг 2026 оны IV дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн	100%
8.4	Дараах чиглэлээр мэргэжил дээшлүүлэх төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрөл авна. Үүнд: - Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын сувилахуйн болон эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын мэдээгүйжүүлгийн сувилахуй - Цус судлалын их эмчийн болон цусны үүдэл эс шилжүүлэн суулгах их эмчийн	-	Сургалтын эрх олгосон шийдвэр	Хөтөл бөрийг мэргэжлийн салбар зөвлөлөөр хянуулж, ЭМХТ-д албан бичгээр хүсэлтээ хүргүүлсэн	Сургалт эрхлэх зөвшөөрлөө авсан байна.	Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын сувилахуйн болон Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын мэдээгүйжүүлгийн сувилахуйн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр хянагдаж дууссан, баталгаажилтын шатанд байна. Цус судлалын их эмчийн болон Цусны үүдэл эс шилжүүлэн суулгах их эмчийн мэргэжил дээшлүүлэх төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр баталгаажсан, сургалтын эрх авах хүсэлтийн ЭМХТ-д өгсөн.	70%

8.5	Төгсөлтийн дараах сургалтад үндсэн мэргэшлийн суралцагч нарын сургалтын явцад ашиглах “Суралцагчийн хөтөч дэвтэр”-ийг хэвлүүлж, ашиглаж эхлүүлнэ.	12.0 (үйл ажилла гааны орлого)	Хэвлүүлсэн сургалтын дэвтрийн ашиглалт	Сургалтын чиглэл бүрээр боловсруулсан суралцагчийн дэвтэртэй	200 ш хэвлүүлсэн, суралцагч нар ашиглаж эхэлсэн байна.	2026 оны III, IV дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн	100%
8.6	БНСУ-ын Ионсей эмнэлэг, ХӨСҮТ-тэй хамтарсан “Халдварт өвчний хяналт сэргийлэлт”-ийн MIRACLE төслийг хэрэгжүүлэн ажиллана.	-	Төслийн хүрээнд хийсэн ажлын тайлан	(-)	Төсөл хэрэгжиж үр дүн гарч эхэлсэн байна	Тайлан хугацаанд MIRACLE төслийг хэрэгжүүлэгч БНСУ-ын Ионсей эмнэлэг, ХӨСҮТ-тэй хамтран дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: УНТЭ-ийн ЭЭСНЛ нь уг төсөлтэй хамтран карбапенемд тэсвэртэй “Klebsiella pneumoniae” үүсгэгчийн молекул-генетикийн онцлог, гарал үүслийг тодорхойлох лабораторийн түвшний судалгааг хийж “LABWEEK-2026”-д илтгэл хэлэлцүүлсэн. Мөн төслийн хүрээнд ХӨСҮТ-д өсгөвөр илгээж, АМЧ-ийн САЗ боловсруулах ажлын хэсэгт хамтран ажиллаж байна. Дээрх Карбапенемд тэсвэртэй Klebsiella pneumoniae үүсгэгчийн геномын дарааллын шинжилгээний үр дүнд үндэслэн тус нянгийн тархвар зүйн онцлог, дамжих зам эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор өвчний түүхэнд	100%

						суурилсан эргэмж судалгааг хийхээр төлөвлөн судалгааны арга, аргачлалыг боловсруулж, 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдөр ХӨСҮТ-ийн талбарын тархвар судлалын албаны хурлаар хэлэлцүүлэн санал, зөвлөмж солилцсон.	
8.7	Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн Бөөрний төв болон Бээжингийн 1-р эмнэлгийн Бөөрний төвийн хамтарсан “Sister clinic” програмын хүрээнд сургалт, семинар зохион байгуулна	-	Сургалт семинарын тайлан	2025 оны 9 сард тэнхимийн сургалт хийгдсэн.	Сургалт, семинарын үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	2026 оны I IV дүгээр улиралд буюу 10 сард зохион байгуулахаар төлөвлөсөн	
ЗОРИЛТ 9: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах							
9.1	Хүн амд зонхилон тохиолдох өвчин эмгэгээс сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох контент, подкаст бэлтгэж нийтийн хүртээл болгох ажлыг эрчимжүүлж, тасралтгүй зохион байгуулна.	-	Бүтээсэн контентийн болон хандалтын тоо	Тогтмол зохион байгуулдаг	10 хүртэлх контент бэлтгэсэн байна.	Тайлант хугацаанд Нийгмийн эрүүл мэндийн албанаас хүн амд зонхилон тохиолдох өвчин эмгэгээс сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох контент, подкаст 10 бэлтгэж нийтийн хүртээл болгосон бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр 8 тэмдэглэсэн. Мөн 101 зурагт мэдээллийг боловсруулан байршуулж, байгууллагын үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний талаарх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлсэн. Эмнэлгийн цахим хуудсанд нийт 1,081,701 удаагийн хандалт бүртгэгдсэн. Линкээр орж үзнэ үү.	100%

						https://www.facebook.com/profile.php?id=61553436448298	
9.2	“Сувилагч зөвлөж байна” хөтөлбөрийн хүрээнд сувилагч нар мэдээлэл зөвлөгөө өгөх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.	-	Зөвлөгөө, мэдээллийн тоо	Зохион байгуулсан сургалт 6	12 удаагийн зөвлөгөө мэдээлэл нийтлэгдсэн байна.	2026 оны III, IV дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн	
ЗОРИЛТ 10: Гамшгийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллах							
10.1	“Хөх код идэвхижүүлэх” сургалтыг нийт эмнэлгийн хэмжээнд зохион байгуулна.	-	- Сургалтын тайлан - Хамрагдсан ажилтнуудын тоо	248 сувилагч, тусгай мэргэжилтн ийг хамруулсан.	Сургалт хийгдэж ажилтнуудын 70 хүртэлх хувийг хамруулсан байна.	2026 оны III дугаар улиралд хийхээр төлөвлөсөн.	
10.2	УНТЭ-ийн “Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх ерөнхий төлөвлөгөө”-г тодотгол хийн батлуулна.	-	Тодотгол хийж арга баталсан хэмжээний төлөвлөгөө	2024 онд тодотгол хийж ОБЕГ-аар батлуулсан.	Төлөвлөгөөг шинэчилж эмнэлгийн захирал болон ОБЕГ-аар батлуулсан байна.	1. Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, СБД-ийн онцгой байдлын хэлтсийн гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн дэд хурандаа А.Түвшинбаатараар батлуулсан. 2. УНТЭ-ийн мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, ОБЕГ-ын АУГ-ын гамшгаас хамгаалах, төлөвлөлт, бэлэн байдлын хэлтсийн дарга хурандаа Б.Одонбаяраар батлуулсан.	100%

10.3	ОБЕГ, ЭМЯ хамтран зохион байгуулах “Гамшгаас хамгаалах команд штаб”-ын үзүүлэх сургалтад оролцоно.	-	Сургалтын тайлан	(-)	Сургалтад нийт ажилтнуудын 50 хүртэл хувь хамрагдсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 11 дүгээр тогтоол, Монгол Улсын Шадар сайдын баталсан “Гамшгаас хамгаалах иж бүрэн команд штабын сургууль зохион байгуулах хуваарь”, Эрүүл мэндийн сайдын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Гамшгаас хамгаалах “Команд штабын сургууль” зохион байгуулах тушаал, Эрүүл мэндийн сайдын 2026.04.24-ны өдрийн Гамшгаас хамгаалах “Команд штабын сургууль” зохион байгуулах тушаал, Эрүүл мэндийн сайдын 2026.04.24-ны өдрийн Гамшгаас хамгаалах “Команд штабын сургууль” зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах тухай 03 тоот албан даалгаврын дагуу УНТЭ нь 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан үзүүлэх сургуулилтад 1. Яаралтай цуглар дохиогоор цугларах, 2. Танхимийн сургалтад хамрагдах, 3. Хээрийн эмнэлэг дэлгэж, нийтийн хамарсан гамшиг ослын үед эмнэлгийн тусламж үйлчилгээг хээрийн нөхцөлд хэрхэн үзүүлэх талаар үзүүлэх сургуулийг зохион байгуулах,
------	--	---	------------------	-----	---	--

						4. Ширээний сургуулилт гэсэн 4 чиглэлээр амжилттай оролцсон.	
10.4	МУХТЖҮЧ 2.2.1 Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг шинэ болон сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үзүүлэх сургуулилалт, сургалт зохион байгуулна.	-	Сургалтын тайлан	Жил бүр зохион байгуулагддаг	Сургалт хийгдэж төв, тасаг, нэгжүүд бүрэн хамрагдсан байна.	2026 оны III дугаар улиралд хийхээр төлөвлөсөн.	
ЗОРИЛТ 11: Хөрөнгө оруулалт							
11.1	Маммографийн аппаратыг хүлээн авч суурилуулан ашиглалтад оруулна.	392.0 (улсын төсөв)	Оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	(-)	100 хүртэлх үйлчлүүлэгч оношилгоонд хамрагдсан байна.	ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар хуваарилагдан ирсэн Маммографийн аппаратыг хүлээн авч, угсралт суурилуултыг хийн үйл ажиллагаанд бүрэн оруулаад байна.	100%
11.2	Эмнэлгийн авто зогсоолын үйл ажиллагааг эхлүүлж, хэвийн үйл ажиллагааг ханган ажиллуулна.	-	Ажлын тайлан, дүгнэлт	2025 онд ашиглалт орж, улсын комисс хүлээн авсан	Авто зогсоол үйл ажиллагаанд орсон байна.	УНТЭ нь цахилгааны хэрэглээг сэргээгдэх эрчим хүчээр 100 хувь хангах боломжтой, дээврийн хэсэгт нарны панель суурилагдсан, 1 жилд ойролцоогоор 60 гаруй сая төгрөгийн ногоон эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай 126 машины зогсоолтой, 5 давхар зогсоолын барилгыг хүлээн авч үйл ажиллагаанд оруулж эхлээд байна. Ашигтай талбай: 4911.82м2 Ажлын талбай: 4245.1 м2 Барилгажилтын талбай: 861.96м2	100%

11.3	Оношилгооны дурангийн угаалга халдваргүйтгэлийг сайжруулах, дурангийн угаалгын машины тоог нэмэгдүүлнэ.	45.0 (үйл ажилла гааны орлого)	Худалдан авсан угаалгын машины тоо	Дурангийн 4 угаалгын машинтай, нэг машин гэмтэлтэй	1 ширхэг угаалгын машиныг нэмж ашиглалтад оруулсан байна.	Худалдан авах үйл ажиллагааг холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулж, ГЭТ-ийн дурангийн хэсэгт нэг дурангийн угаалгын машин худалдан авч байршуулан үйл ажиллагаанд бүрэн оруулаад байна.	50%
ЗОРИЛТ 12: Дэмжих үйл ажиллагааны чиглэлээр							
12.1	ДОТ-ийн 2 давхарт байрлах компьютер томографи аппаратыг засвар үйлчилгээ хийж ашиглалтад оруулна.	646.0 (үйл ажилла гааны орлого)	- Засвар үйлчилгээний гэрээ - Засварын тайлан	Тус аппарат нь 2022 онд угсралт хийгдсэн, рентген тубе шатсан	Баталгаат засвар үйлчилгээний гэрээ байгуулагдаж, засвар хийгдсэн байна	Өндөр өртөгт тоног төхөөрөмжийн баталгаат засвар үйлчилгээний тендер зарлан худалдан авалтыг зохион байгуулж, компьютер томографи аппаратын гэмтлийг засварлан, шалгалт тохируулгыг хийж 2026 оны 5 сараас аппаратыг ашиглалтанд оруулсан.	100%
12.2	Эмнэлгийн хэмжээнд ашиглагдаж буй оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжүүдийг “Эм, эмнэлгийн хэрэгсэл, хяналт зохицуулалтын газар”-ын баталгаажуулалтад хамруулна.	47.2 (үйл ажилла гааны орлого)	Баталгаажилтад хамрагдсан тоног төхөөрөмжийн тоо, гэрчилгээ	2024 онд шаардлагатай тоног төхөөрөмжү үд ийг хамруулсан.	Нийт 412 тоног төхөөрөмж шалгалт баталгаажуулалтад хамрагдсан байна	2026 оны IV дүгээр улиралд хийхээр төлөвлөсөн.	
12.3	Эмнэлгийн А блокт байрлах цахилгаан шатыг бүрэн шинэчилж, засвар үйлчилгээний гэрээ байгуулан хэвийн үйл ажиллагааг ханган ажиллана.	250.0 (үйл ажилла гааны орлого)	- Засвар үйлчилгээний гэрээ - Хийсэн ажлын тайлан	2007 онд анх суурилагд сан.	Үйлчилгээний гэрээ байгуулагдаж, цахилгаан шатны хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна.	2026 оны төсөвт А блокт байрлах цахилгаан шатыг бүрэн шинэчилж, засвар үйлчилгээний гэрээ байгуулан ажиллах төсвийг тусгасан боловч хасагдсан. Хагас жилийн төсвийн тодотголд дахин тусгаж батлагдсан тохиолдолд	50%

						тухайн ажлыг хийж гүйцэтгэнэ.	
12.4	Эмнэлгийн аянга зайлуулагч, газардуулгын хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, цахилгаан энергийн хэмжилт хийнэ.	30,0 (үйл ажилла гааны орлого)	Газардуулгын протокол	2025 онд хийгдсэн.	Газардуулга, энергийн хэмжилтийг хийлгэж протокол авсан байна.	Инженерийн байгууламжийн албанаас эмнэлгийн хэмжээний аянга зайлуулагчийг 12 цэгт, газардуулгын эсэргүүцлийг 8 цэгт хэмжилт хийлгэж баталгаажуулаад газардуулгын протоколыг авсан. Эсэргүүцэл /0,1-4 ом/ норм дүрмийг хангаж байна.	100%
12.5	Харааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд зориулан амбулаторийн үзлэгийн кабинетүүдийн хаягийг брайл үсгээр бичиж байршуулна.	-	Брайл үсгээр хаягжуулсан өрөөний тоо	2025 онд хийгдэж байсан	Нийт 30 кабинет брайл үсгийн хаягтай болсон байна	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг нь хөгжлийн бэрхшээлтэй, тэр дундаа харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан хүртээмжтэй орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд мэс засалд орох үйлчлүүлэгч нарт зориулсан Браиль үсэгтэй гарын авлага, мэдээллийн материалыг хэвлүүлэн үйлчилгээнд нэвтрүүлсэн. Мөн амбулаторийн 2,3,4 давхарын 10 кабинетэд брайль үсгэн хаяг байршуулсан.	50%



Брайл үсгийн хаяг

12.6	Суралцагч нарын сургалтын орчныг сайжруулах, засвар хийх, сургалтын үйл ажиллагаанд ашиглагддаг ширээ сандлыг шинэчлэх, компьютерын тоог нэмэгдүүлнэ.	40.0 (төсөл хөтөл бөр)	Засвар, тохижилтийн тайлан	2019 онд засвар хийгдсэн	Засвар хийгдэж, орчин сайжирсан сургалтын нөхцөл байна.	Тайлант хугацаанд суралцагч нарын нийтийн хувцас солих өрөөг өөр байршилд шилжүүлж, 7 давхарт байрлах сургалтын орчин нөхцөлийг сайжруулсан. Цаашид хандив тусламжаар засвар тохижилтийн ажлыг хийхээр төлөвлөж байна.	50%
12.7	Галын аюулгүй байдлын сургалтыг Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын ерөнхий газартай хамтран зохион байгуулна.	-	Сургалтын тайлан, удирдамж, хамрагдсан ажилтны тоо	Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвтэй хамтран 118 ажилтныг хамруулсан сургалт зохин байгуулсан	Нийт 250 хүртэлх ажилтныг сургалтад хамруулсан байна	2026 оны IV дүгээр улиралд хийхээр төлөвлөсөн.	100%